

## МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН 2006 ОНЫ АЖЛЫН ТАЙЛАН

Илтгэгч нь: Ерөнхий шүүгч  
С.Батдэлгэр

Эрхэм шүүгч, ажилтнууд аа!

Энэ жил Монгол Улсын Дээд шүүх шүүх эрх мэдлийг Үндсэн хууль болон бусад хуульд нийцүүлэн хэрэгжүүлэх, шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг хангах, шүүн таслах ажиллагааны чанар, үр нөлөөг дээшлүүлэх, шүүхийн үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцлөөр хангах, шүүгч, ажилтнуудын сахилга, хариуцлага, ёс зүй, ажил хэргийн чадвар, мэргэшлийн түвшинг дээшлүүлэх, шүүгчдийн эрх ашгийг хамгаалах, шүүхийн үйл ажиллагааг олон нийтэд ил тод, нээлттэй болгох, шүүхийн үйл ажиллагааны эрх зүйн орчинг шинэчлэн сайжруулах, шүүхийн менежментийг боловсронгуй болгох зэрэг асуудлуудад анхаарлаа хандуулан ажиллаж ирлээ.

Улиран өнгөрч буй 2006 он Их Монгол Улс байгуулагдсаны 800, Монгол Улсад шүүх байгуулагдсаны 80 жилийн түүхэн ойнууд давхацсан ажил хөдөлмөрийн өрнүүн жил байлаа.

Шүүгч, ажилтнуудын хөдөлмөр, зүтгэлийг Монголын төр өндрөөр үнэлж Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн ажлын албаны дарга асан Н.Төрбат **“Монгол Улсын гавьяат хуульч”** цолоор;

Ерөнхий шүүгч С.Батдэлгэр, шүүгч Д.Пунцаг, шүүгч агсан Р.Жамьянчойжил, Судалгааны төвийн захирал Б.Дангаасүрэн нар **“Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон”**-гоор;

Шүүгч Л.Атарцэцэг **“Алтан гадас”** одонгоор;

Шүүгч Ч.Тунгалаг, Архив, номын сан хариуцсан мэргэжилтэн Ж.Тэгшдэлгэр нар **“Хөдөлмөрийн хүндэт медаль”**-иар;

Улсын Дээд шүүхийн шүүгч, ажилтан 21 хүн **“Их Монгол Улс байгуулагдсаны 800 жилийн ойн медаль”**-иар;

Мөн Захиргааны хэргийн танхимын тэргүүн О.Зандраа, шүүгч Ч.Ганбат нар **“Шүүхийн тэргүүний ажилтан”** цол, тэмдгээр;

Шүүгч Б.Ундрах Шүүхийн Ерөнхий зөвлөлийн **“Хүндэт тэмдэг”**-ээр;

Шүүгч Д.Тунгалаг, С.Нямжав нар **“Хууль зүйн албаны тэргүүний ажилтан”** цол тэмдгээр;

Захиргааны хэргийн танхимын тэргүүний туслах-шинжээч С.Мөнхжаргал Монголын Залуучуудын Холбооны **“Хөдөлмөрийн алдар”**, Компьютерийн техник хангамжийн асуудал хариуцсан референт Д.Мөнхзориг, Бичиг хэрэг, өргөдөл, гомдол хариуцсан мэргэжилтэн Д.Оюунчимэг нар **“Тэргүүний залуу”** алтан медалиар;

Жолооч Б.Энхжаргал Замын цагдаагийн газрын **“Осолгүй манлай жолооч”** тэмдгээр тус тус шагнагдлаа.

Тайлангийн хугацаанд **Б.Бат-Эрдэнэ, Л.Бямбаа, Б.Ундрах, Ц.Сумъяа** нар Улсын Дээд шүүхийн шүүгчийн албан тушаалд томилогдон ажиллалаа.

Улсын Дээд шүүхийн санал болгосноор Улсын Их Хурлын 2006 оны 53 дугаар тогтоолоор **“Шүүгчид зэрэг дэв олгох журам”**-ыг шинэчлэн баталж, уг журамд заасан болзлыг хангасан тул Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгч С.Батдэлгэр, Танхимын тэргүүн Д.Батсайхан, Ц.Амарсайхан, О.Зандраа, шүүгч Б.Бат-Эрдэнэ, Л.Бямбаа, А.Доржготов, Б.Доржготов, Д.Тунгалаг нарын 9 шүүгчид шүүгчийн **“Тэргүүн түшээ”**, шүүгч Ч.Тунгалагт Шүүхийн Ерөнхий зөвлөлийн тогтоолоор **“Дэд түшээ”** зэрэг дэвийг тус тус олголоо.

Улсын Дээд шүүхийн эрүү, иргэн, захиргааны хэргийн танхимын тэргүүнүүд болон шүүгчид Эрүү, Эрүүгийн байцаан шийтгэх, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах Засгийн газар, Улсын Их Хурлын ажлын хэсэгт орон ажиллаж байна.

Шүүгч Л.Бямбаа “Шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг хангах эрх зүйн асуудлууд” сэдвээр хууль зүйн ухааны доктор /Ph.D/-ын зэрэг хамгаалсан нь шүүхийн түүхэнд шүүгчээр ажиллаж байх үедээ эрдмийн цол авсан анхны тохиолдол боллоо.

“Улсын Дээд шүүхийн хөдөлмөрийн дотоод журам”, “Шүүхийн судалгааны төвийн дүрэм”, “Улсын Дээд шүүхээс улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчийг цагаатгасан тухай үнэмлэх олгох журам”, “Flash диск ашиглах журам”-ыг Ерөнхий шүүгчийн захирамжаар тус тус шинэчлэн батлаж, өнгөрсөн онд батлагдсан журмуудтай нэгтгэн, товхимол болгон хэвлүүлж, олны хүртээл болголоо.

Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгч 5 дугаар сарын 17-ны өдөр 1/1463 тоот **албан захидлаар** бүх шатны шүүхийн шүүгч, ажилтнуудад хандан “Шүүх эрх мэдлийн стратеги төлөвлөгөө”-г үргэлжлүүлэн хэрэгжүүлэх, шүүхийн болон эрх зүйн өөрчлөлт, шинэчлэлийг тууштай хийх замаар хууль ёс, хүний эрх, эрх чөлөө, шудрага ёсны баталгаа болсон, орчин үеийн, дэлхийн жишигт нийцэхүйц шүүх эрх мэдлийн байгууллагыг төгөлдөржүүлэн бүрдүүлэх эрхэм зорилтыг хэрэгжүүлэхэд шүүгч, ажилтнуудын хүчин зүтгэл чухал гэдгийг тэмдэглээд, хамтын хүчээр хийж бүтээсэн ажлуудыг дурьдаж, цаашид баримтлан ажиллах бодлого, чиглэлээ тодорхойллоо.

Улсын Дээд шүүх 2006 онд **88** ажил төлөвлөснөөс нь **82** нь бүрэн биелэж, **3** нь тодорхой шалтгааны улмаас хийгдэлгүй, **2** нь хойшлогдож, **1** нь тасалдсан байна. Тухайлбал:

Нийгмийн даатгалын болон Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулиудад нэмэлт, өөрчлөлт орох болсонтой, Патентын хууль шинэчлэн батлагдсантай холбогдон, уг хуулиудын зарим зүйл, заалтыг тайлбарлуулахаар хүсэлт гаргасан байгууллагууд саналаасаа татгалзсан тул эдгээр хуулийн тайлбарууд гарсангүй.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн дэлгэрэнгүй тайлбарыг Иргэний хэргийн танхим боловсруулж хэвлэлтэд өгсөн, **Эрүүгийн** болон **Иргэний** түүнчлэн **Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн дэлгэрэнгүй тайлбар** боловсруулах ажлын хэсгийнхэн одоогоор ажиллаж байна.

Харин шүүгч, ажилтнуудыг “Байгалийн үзэсгэлэнт газар”-аар аялуулах ажил хүндэтгэн үзэх шалтгааны улмаас тасалдсан байна.

Шүүгчдийг БНСУ-д богино хугацааны сургалтад хамруулах ажил тус улсын Дээд шүүх Монголын Улсын шүүхийн шүүгчдээс урт хугацааны сургалтад тухайлбал жилд 1-2 хүнийг магистр, докторантурт сургах болсонтой холбогдон хийгдсэнгүй. Энэ онд магистрын сургалтанд Нийслэлийн захиргааны хэргийн шүүхийн шүүгч Н.Дуламсүрэн хамрагдахаар явсан байна.

**Шүүгчдийн зөвлөлийн хуралдааныг** 1 дүгээр сарын 20-ны өдөр зарлан хуралдуулж, Шүүхийн Ерөнхий зөвлөлийн бүрэлдэхүүнд Нийслэлийн шүүхээс орох шүүгчийг сонгох, Шүүгчдийн холбооны дүрмийг шинэчлэн батлах, Шүүгчдийн холбооны тэргүүн, гүйцэтгэх захирал, удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох зэрэг асуудлыг хэлэлцээд **Шүүхийн Ерөнхий зөвлөлийн гишүүнээр** Нийслэлийн шүүхийн Ерөнхий шүүгч **Ц.Зориг**, **Шүүгчдийн холбооны тэргүүнээр** Улсын Дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимын тэргүүн **О.Зандраа**, тус холбооны **Гүйцэтгэх захирлаар** Улсын Дээд шүүхийн Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах албаны дарга **М.Дамирансүрэн** нар сонгогдон ажиллаж байна.

ХБНГУ-ын “Ханнс–Зайделийн сан”-гийн санхүүгийн дэмжлэг туслалцаатайгаар **Аймаг, нийслэл, нийслэлийн захиргааны хэргийн болон зарим сум дунд, дүүргийн шүүхийн Ерөнхий шүүгчдийн Нэгдсэн зөвлөгөөн, семинарыг** 2006 оны 1 дүгээр сарын 18-наас 24-ний өдрүүдэд Төр, засгийн үйлчилгээний “Элит” төвд зохион байгуулав.

АНУ-ын “Шүүх эрх мэдлийн шинэтгэлийн хөтөлбөр” төслийн санхүүгийн дэмжлэг туслалцаатайгаар “**Шүүх эрх мэдлийн байгууллагын мэдээллийн төв**”-ийг байгуулж, сар бүр

шүүхийн үйл ажиллагааны болон нийгэмд дуулиан тарьж буй хэргийн талаар Улсын Дээд шүүх дангаараа болон холбогдох шүүхүүдтэй хамтран хэвлэл, мэдээллийн байгууллагуудад нийт 11 удаа мэдээлэл хийлээ.

Дэлхийн банкны “Шүүх, эрх зүйн шинэчлэлт” төслийн санхүүгийн дэмжлэг тусалцаатайгаар “**Шүүхийн мэдээллийн нэгдсэн систем**”-ийг Улсын Дээд шүүхэд байгууллаа. Энэхүү мэдээллийн нэгдсэн системийг бүрэн ашиглах, улам боловсронгуй болгох нь ажлын ачааллыг хөнгөлөх, иргэд, хуулийн этгээдэд шүүхийг ил тод, нээлттэй болгох, мэдээллийг түргэн шуурхай хүргэх зэрэг олон давуу талыг бүрдүүлж байгаагаараа онцгой ач холбогдолтой юм.

“**Улсын Дээд шүүхийн Вэб сайт**”-д тус шүүхийн үйл ажиллагаатай холбоотой мэдээ, мэдээлэл, тогтоол, шүүх хуралдааны зар, хэрэг хянан шийдвэрлэлтийн байдал зэргийг тухайн долоо хоногт гаргаж хэвшлээ.

Шүүхийн 2005 оны ажлын тайланг ном болгон хэвлүүлж, нийтийн хүртээл болголоо. Мөн Улсын Дээд шүүхийн болон Шүүхийн Ерөнхий зөвлөлийн тухай танилцуулгыг англи хэл дээр хэвлүүлэн гаргалаа.

“**Албан тушаалтны хөрөнгө, орлогын мэдүүлгийн маягт, түүнийг бүртгэх, хадгалах журам**”-д заасны дагуу шүүгч, захиргааны албан хаагчдаас “**Албан тушаалтны хөрөнгө, орлогын мэдүүлэг**”-ийг 2005 оны байдлаар гаргуулан авч, Шүүхийн Ерөнхий зөвлөлд хадгалуулж байна.

Улсын Их Хурлаас 2006 оны 1 дүгээр сарын 12-ны өдөр баталсан Эрүүгийн байцаан шийтгэх хуульд нэмэлт оруулах тухай, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Захиргааны хариуцлагын тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль нь Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх талаар Улсын Дээд шүүхээс гаргасан хүсэлтийн дагуу үүссэн маргааныг Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанаар 4 дүгээр сард, 2006 оны 7 дугаар сарын 5-ны өдөр их суудлын хуралдаанаар тус тус хянан хэлэлцэж, хүсэлтийг хангаж шийдвэрлэлээ.

Улсын Дээд шүүхийн шүүгч, ажилтнуудын шилжилт, хөдөлгөөний тайланг компьютерийн шинэчлэсэн программын дагуу гарган Төрийн албаны зөвлөлд хүргүүллээ.

Улсын Дээд шүүхийн эрүү, иргэн, захиргааны хэргийн танхимын шүүн таслах ажиллагааны дүн мэдээ гарч, Танхимууд, Тамгын газар, Шүүхийн судалгааны төвийн тайлан гарлаа. Ингээд Дээд шүүхийн 2006 оны **Нэгдсэн тайланг** товч танилцуулъя.

### **Нэг. Шүүн таслах ажиллагааны талаар**

Улсын Дээд шүүхийн Нийт шүүгчдийн хуралдааныг 14 удаа зарлан, нийт 14 өдөр хуралдуулж, бүгд 62 асуудал хэлэлцэж, 57 тогтоол, 1 тэмдэглэл гаргасны дотор, эрүүгийн 17, иргэний 4, захиргааны 1, хуулийн тайлбар 27, аймгийн шүүхийг шалган тусласан дүнгийн тухай 6, бусад 7 асуудлыг хэлэлцэж шийдвэрлэсэн байна.

Өнгөрсөн жилтэй харьцуулахад Улсын Дээд шүүхийн Нийт шүүгчдийн хуралдаан хийсэн өдөр 2-оор, хэлэлцсэн асуудлын тоо 18-аар, хуулийн тайлбар 24-өөр тус тус нэмэгдэж, эрүүгийн хэрэг 14-өөр, иргэний хэрэг 1-ээр тус тус буурчээ.

### **Эрүүгийн хэргийн танхим**

Эрүүгийн хэргийн танхим нь хяналтын журмаар эрүүгийн 740, цагаатгалын 19, нийт 759 хэрэг хүлээн авч, түүний 94 хувь буюу эрүүгийн 712, цагаатгалын 2,5 хувь буюу 19 хэргийг хянаж шийдвэрлэжээ.

**Хяналтын журмаар** Танхимын тэргүүн Д.Батсайхан 189, шүүгч С.Нямжав 128, Ч.Ганбат 118, Б.Доржготов 109, Б.Бат-Эрдэнэ 106, Танхимын тэргүүн О.Зандраа, шүүгч Л.Атарцэцэг, Д.Пунцаг нар тус бүр 6, шүүгч Ч.Тунгалаг, П.Цэцгээ нар тус бүр 5, Ерөнхий шүүгчийн ажлын алба

**81** эрүүгийн хэрэг хүлээж авсан ба **541** эрүүгийн хэргийг шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэж, **190** эрүүгийн хэргийг хянан буцааж, одоо эрүүгийн хэргийн танхимд **11**, Ерөнхий шүүгчийн ажлын албанд **17** хэргийн үлдэгдэлтэй байна.

**Хяналтын шатны** эрүүгийн хэргийн шүүх хуралдаанд Танхимын тэргүүн Д.Батсайхан **488**, шүүгч Ч.Ганбат **489**, Б.Бат-Эрдэнэ **444**, С.Нямжав **434**, Б.Доржготов **386** удаа тус тус оролцсоноос;

Танхимын тэргүүн Д.Батсайхан **393**, шүүгч Ч.Ганбат **54**, Б.Доржготов **43**, С.Нямжав **33**, Б.Бат-Эрдэнэ **2** хэргийн шүүх хуралдааныг тус тус даргалж;

Танхимын тэргүүн Д.Батсайхан **95**, шүүгч С.Нямжав **119**, Ч.Ганбат **111**, Б.Доржготов **99**, Б.Бат-Эрдэнэ **90**, Танхимын тэргүүн О.Зандраа, шүүгч Л.Атарцэцэг, Д.Пунцаг нар тус бүр **6**, Ч.Тунгалаг **5**, П.Цэцгээ **4 хэрэг тус тус илтгэсэн** байна.

**Эрүүгийн хэргийн танхимын** хяналтын шатны шүүх хуралдаан нийт **73** өдөр хуралдаж, **өдөрт 2-18** хэрэг хэлэлцэж, бүгд **541** хэрэг хянан шийдвэрлэсний **96,5** хувь буюу **522** нь эрүүгийн, **3,5** хувь буюу **19** нь цагаатгалын хэрэг байв.

Улсын Дээд шүүхийн **хяналтын шатны** эрүүгийн хэргийн шүүх хуралдаанаар хэлэлцэгдсэн **541** эрүүгийн хэргийн **59,3** хувь буюу **321** тогтоол, магадлалыг **хэвээр** үлдээж, **12,8** хувь буюу **69** нь **өөрчлөгдөж**, **27,9** хувь буюу **151** тогтоол, магадлалыг **хүчингүй** болгожээ.

Өөрчлөгдсөн **69** тогтоол, магадлалын **31,9** хувь буюу **22** нь Эрүүгийн хууль буруу хэрэглэсэн, **18,8** хувь буюу **13** нь шүүх хэрэглэвэл зохих хуулийг хэрэглээгүй, **2,9** хувь буюу **2** нь хэрэглэх ёсгүй хуулийг хэрэглэсэн, **5,8** хувь буюу **4** нь хуулийг жинхэнэ агуулгаас зөрүүтэй буруу ойлгож хэрэглэсэн, **40,6** хувь буюу **28** нь шийтгэх тогтоол, магадлалд бусад өөрчлөлт оруулжээ.

Хүчингүй болгосон **151** тогтоол, магадлалтай хэргээс **69** хэргийг нэмэлт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт хийлгэхээр прокурорт, **33** хэргийг **шүүхээр дахин хэлэлцүүлэхээр** буцааж, **27** хэргийг **хэрэгсэхгүй** болгож, бусад буюу шийтгэх тогтоол, магадлалын зарим заалт, хэсгийг хүчингүй болгосон **22** хэрэг байна.

Улсын Дээд шүүхийн хяналтын шатны эрүүгийн хэргийн шүүх хуралдаанаар хэлэлцэгдсэн **19** цагаатгалын хэргийн **10,5** хувь буюу **2-д** нь хэлмэгдэгсдийн овог, нэрийг өөрчилж, **89,5** хувь буюу **17** хүнд холбогдох хэргийг гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй гэсэн үндэслэлээр хэрэгсэхгүй болгон тэднийг цагаатгажээ.

Улсын Дээд шүүхийн **Нийт шүүгчдийн** хуралдаанаар эрүүгийн **17** хэрэг хянан хэлцэгдсэний **3** нь Ерөнхий шүүгчийн дүгнэлтээр, **1** нь шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас прокурорын дүгнэлтээр, **13** нь цаазаар авах ялтай хэрэг байв.

Хяналтын шатны эрүүгийн хэргийн шүүх хуралдаанаар шийдвэрлэсэн хэргийн **82,4** хувь буюу **446** нь ялтан, өмгөөлөгч, хохирогч, тэдний хууль ёсны төлөөлөгчийн гомдлоор, **12,4** хувь буюу **67** нь яллагчийн эсэргүүцлээр, **5,2** хувь буюу **28** нь прокурорын дүгнэлтээр хэлэлцэгджээ.

Тайлангийн хугацаанд Танхимын тэргүүн Д.Батсайхан **93**, шүүгч Б.Бат-Эрдэнэ **13**, С.Нямжав **8**, Б.Доржготов **8**, Ч.Ганбат **3**, П.Цэцгээ **1** хэргийг тус тус хянан Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн зохих заалтуудыг зөрчсөн эсвэл гомдол гаргах хугацаа хэтэрсэн хэргүүдийг дахин нягтлуулахаар, Ерөнхий шүүгчийн ажлын алба **64** хэргийг хянан зохих хариу өгөх байдлаар тус тус буцаасан байна.

Тус танхим 2006 онд нийт **236** өргөдөл, гомдол хүлээн авснаас Танхимын тэргүүн Д.Батсайхан **192**, шүүгч Б.Доржготов **10**, С.Нямжав **9**, Ч.Ганбат **8**, Б.Бат-Эрдэнэ **5** өргөдлийг тус тус хянан шийдвэрлэж, одоо **12 өргөдлийн** үлдэгдэлтэй байна.

Хяналтын шатны **иргэний** хэргийн шүүх хуралдаанд Танхимын тэргүүн Д.Батсайхан **6** удаа оролцсоноос **2** удаа шүүх хуралдааныг даргалж, шүүгч С.Нямжав **39**, Б.Бат-Эрдэнэ **23**, Б.Доржготов **8**, Ч.Ганбат **4**, **захиргааны** хэргийн шүүх хуралдаанд Танхимын тэргүүн Д.Батсайхан **29**, шүүгч Б.Бат-Эрдэнэ **46**, Ч.Ганбат **36**, Б.Доржготов **27**, С.Нямжав **20** удаа тус тус оролцож, Танхимын тэргүүн Д.Батсайхан **7** удаа шүүх хуралдааныг даргалжээ.

## Иргэний хэргийн танхим

Иргэний хэргийн танхим иргэд, байгууллагаас нийт **140** өргөдөл, гомдол хүлээн авч, **134**-г нь буюу **95,7** хувийг шийдвэрлэжээ. Үүнд: Танхимын тэргүүн Ц.Амарсайхан **126**, шүүгч Д.Тунгалаг **2**, А.Доржготов **2**, Л.Бямбаа **2**, Б.Ундрах **2**-ыг тус тус хянан шийдвэрлэж, одоо **6** өргөдөл, гомдлын үлдэгдэлтэй байна.

Энэ онд тус танхим өмнөх оны үлдэгдэл **33** хэрэг дээр **хяналтын журмаар** нийт **1046** хэрэг шинээр хүлээн авч, нийт **1079** хэргээс иргэний **777** хэргийг **5 шүүгчийн бүрэлдэхүүнтэй** хяналтын шатны шүүх хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэж, дүгнэлт гаргуулахаар гомдол гаргасан **196** хэргийг Ерөнхий шүүгчийн ажлын албанд шилжүүлж, **59** хэргийг хяналтын журмаар хэлэлцэхээс татгалзаж шийдвэрлэжээ. Одоо хяналтын шатны шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх **33**, Ерөнхий шүүгчид дүгнэлт гаргуулахаар гомдол гаргасны дагуу хянагдаж байгаа **14** хэргийн үлдэгдэлтэй байна.

Танхимын тэргүүн Ц.Амарсайхан **83** хэрэг хүлээн авч, **81-г шийдвэрлэж**, үүнээс **67** хэргийг хуралдаанд илтгэж шийдвэрлүүлсэн;

Шүүгч А.Доржготов **199** хэрэг хүлээн авч, **191** хэргийг шийдвэрлэж, үүнээс **189** хэргийг хуралдаанд илтгэж шийдвэрлүүлсэн;

Шүүгч Д.Тунгалаг **199** хэрэг хүлээн авч, **194-г** шийдвэрлэж, үүнээс **176** хэргийг хуралдаанд илтгэж шийдвэрлүүлсэн;

Шүүгч Б.Ундрах **194** хэрэг хүлээн авч, **186** -г шийдвэрлэж, үүнээс **174** хэргийг хуралдаанд илтгэж шийдвэрлүүлсэн;

Шүүгч Л.Бямбаа **194** хэрэг хүлээн авч, **184-г** шийдвэрлэж, үүнээс **171** хэргийг хуралдаанд илтгэж шийдвэрлүүлжээ.

**Иргэний хэргийн хяналтын** шатны шүүх хуралдаан **68** өдөр хуралдаж, өдөрт дунджаар **11** хэрэг хэлэлцэн, нийт **777** хэрэг хянаж шийдвэрлэжээ.

Танхимын тэргүүн Ц.Амарсайхан **743** хэрэг шийдвэрлэхэд **оролцсоноос 676** хуралдааныг,

Шүүгч Л.Бямбаа **706** хэрэг шийдвэрлэхэд оролцсоноос, **16** хуралдааныг,

Шүүгч А.Доржготов **671** хэрэг шийдвэрлэхэд оролцсоноос, **46** хуралдааныг,

Шүүгч Б.Ундрах **629** хэрэг шийдвэрлэхэд оролцсоноос **8** хуралдааныг,

Шүүгч Д.Тунгалаг **572** хэрэг шийдвэрлэхэд оролцсоноос, **15** хуралдааныг тус тус даргалжээ.

Хяналтын шатны эрүүгийн хэргийн шүүх хуралдааныг Танхимын тэргүүн Ц.Амарсайхан **4** удаа даргалж, **6** шүүх хуралдаанд оролцсон бол шүүгч Б.Ундрах **43**, Л.Бямбаа **42**, А.Доржготов **21**, Д.Тунгалаг **6** шүүх хуралдаанд оролцсон байна.

Захиргааны хэргийн танхимын **хяналтын** шатны шүүх хуралдааныг Танхимын тэргүүн Ц.Амарсайхан **7** удаа даргалж, **11** хуралдаанд оролцсон, шүүгч Б.Ундрах **31**, Л.Бямбаа **26**, Д.Тунгалаг **17**, А.Доржготов **11** хуралдаанд тус тус оролцжээ.

Захиргааны хэргийн **давж заалдах** шатны шүүх хуралдааныг Танхимын тэргүүн Ц.Амарсайхан **1** удаа, шүүгч Л.Бямбаа **1** удаа тус тус даргалж, Танхимын тэргүүн Ц.Амарсайхан **1**, шүүгч Б.Ундрах **20**, Л.Бямбаа **23**, А.Доржготов **17**, Д.Тунгалаг **7** удаа тус тус шүүх хуралдаанд оролцож, шүүгч Б.Ундрах **1** хэрэг илтгэн хэлэлцүүлжээ.

Иргэний хэргийн танхим 2006 онд Танхимын тэргүүний болон шүүгчийн захирамж **561**-ийг гаргаснаас “гомдол хэлэлцүүлэхээс татгалзах тухай” шүүгчийн захирамж **38**, “гомдол гаргаагүйд тооцох тухай” шүүгчийн захирамж **5**, “улсын тэмдэгтийн хураамж буцаан олгох тухай” шүүгчийн захирамж **163**, Танхимын тэргүүний “шүүх бүрэлдэхүүн томилох тухай” захирамж **325**, “улсын тэмдэгтийн хураамж буцаан олгох тухай” захирамж **30** байна.

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.3-т заасан хугацаанд холбогдох баримт бичгийг Улсын Дээд шүүхэд ирүүлж, шинэчилсэн бүртгэлд хамрагдаагүй тул мөн зүйлийн 28.4-т заасны дагуу **Монгол Ардын Нам, Монголын Ажилчны Нам, Монголын Уламжлал Шударга Ёсны Нам, Монголын Ардчилсан Социалист Нам, Монголын Залуучуудын Нам, Монголын Коммунист Нам, Монголын Хөдөөгийн Хөгжлийн**

**Нам, Монголын Шинэ Социал Демократ Нам, Монголын Угсаатны Нэгдсэн Социалист Нам** гэсэн **9** намыг татан буулгах тухай асуудлыг шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэжээ.

Иргэний Зориг-Бүгд Найрамдах Нам нэрээ **“Иргэний Зориг Нам”** гэж өөрчилснийг улсын бүртгэлд бүртгэж, улсын бүртгэлийн гэрчилгээ олгожээ.

Монгол Ардын Хувьсгалт Нам, Ардчилсан Нам тус тус намын дүрэмдээ өөрчлөлт оруулсныг улсын бүртгэлд бүртгэсэн бол **“Үндэсний Шинэ Нам”**-ыг улсын бүртгэлд бүртгэж, улсын бүртгэлийн гэрчилгээ олгосон байна.

Улс төрийн намуудын бүртгэлийг хуульд зааснаар цахим сүлжээнд оруулж, гэрчилгээг шинэчлэх, регистр олгох ажиллагааг хийж дуусгалаа.

Иргэний хэргийн танхим бусдаасаа илүү их ачаалалтай, хүртээмжтэй, бүтээмжтэй ажилласныг зориуд цохон тэмдэглэж, талархал илэрхийлье.

### **Захиргааны хэргийн танхим**

Захиргааны хэргийн танхим 2006 онд **давж заалдах журмаар 180, хяналтын журмаар 144**, бүгд **324** хэрэг хүлээн авчээ.

**Давж заалдах** журмаар ирүүлсэн захиргааны хэргээс **159**-г нь шүүх хуралдаанаар хянан хэлэлцэж, **12** хэргийг хуралдаанд оруулахгүйгээр шийдвэрлэн, одоо **9** хэргийн үлдэгдэлтэй байна.

**Хяналтын** журмаар ирүүлсэн захиргааны хэргийн **36** нь Ерөнхий шүүгчид, **106** нь шүүхийн шийдвэр, магадлалыг эс зөвшөөрч хяналтын журмаар, **2** нь шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас гаргасан гомдол байв.

Хяналтын журмаар ирүүлсэн **106** захиргааны хэргээс **101**-г нь шүүх хуралдаанаар хянан хэлэлцэж, **2** хэргийг хуралдаанд оруулахгүйгээр шийдвэрлэж, одоо хяналтын журмаар хянагдах **3** хэргийн үлдэгдэлтэй байна.

Танхимын тэргүүн О.Зандраа хяналтын журмаар **23** хэрэг хүлээн авснаас, хяналтын шатны шүүх хуралдаанаар **21** хэрэг;

Шүүгч П.Цэцгээ давж заалдах журмаар **45**, хяналтын журмаар **23** хэрэг хүлээж авснаас давж заалдах шатны шүүх хуралдаанаар **40**, хяналтын шатны шүүх хуралдаанаар **22** хэрэг;

Шүүгч Л.Атарцэцэг давж заалдах журмаар **45**, хяналтын журмаар **17** хэрэг хүлээж авснаас давж заалдах шатны шүүх хуралдаанаар **40**, хяналтын шатны шүүх хуралдаанаар **16** хэрэг;

Шүүгч Ч.Тунгалаг давж заалдах журмаар **44**, хяналтын журмаар **21** хэрэг хүлээж авснаас давж заалдах шатны шүүх хуралдаанаар **39**, хяналтын шатны шүүх хуралдаанаар **21** хэрэг;

Шүүгч Д.Пунцаг давж заалдах журмаар **43**, хяналтын журмаар **22** хэрэг хүлээж авснаас давж заалдах шатны шүүх хуралдаанаар **40**, хяналтын шатны шүүх хуралдаанаар **21** хэрэг тус тус илтгэж шийдвэрлүүлжээ.

Давж заалдах шатны шүүх хуралдааныг **38**, хяналтын шатны шүүх хуралдааныг **32** өдөр тус тус хийж, өдөрт дунджаар **4** хэрэг хэлэлцэн, нийт **260** хэргийг хянан шийдвэрлэжээ.

Хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдаанд Танхимын тэргүүн О.Зандраа **95** удаа оролцсоноос **72**, шүүгч Ч.Тунгалаг **55** удаа оролцсоноос **8**, шүүгч П.Цэцгээ **53** удаа оролцсоноос **1**, шүүгч Д.Пунцаг **49** удаа оролцсоноос **1**, шүүгч Л.Атарцэцэг **44** удаа оролцсоноос **3** хуралдааныг тус тус даргалсан байна.

Захиргааны хэргийн танхимын давж заалдах шатны шүүх хуралдаанд шүүгч П.Цэцгээ **89** удаа оролцсоноос **41**, Л.Атарцэцэг **89** удаа оролцсоноос **39**, Д.Пунцаг **84** удаа оролцсоноос **41**, Ч.Тунгалаг **76** удаа оролцсоноос **36** хуралдааныг тус тус даргалжээ.

Ерөнхий шүүгчид гомдол гарган ирүүлсэн хэргүүдээс Танхимын тэргүүн О.Зандраа 1 хэргийг Нийт шүүгчдийн хуралдаанаар илтгэн хэлэлцүүлж, шийдвэрлүүлсэн байна.

Хяналтын шатны **эрүүгийн** хэргийн шүүх хуралдаанд Танхимын тэргүүн О.Зандраа **55** удаа оролцсоноос **6**, шүүгч Д.Пунцаг **84** удаа оролцсоноос **6**, Л.Атарцэцэг **75** удаа оролцсоноос **6**, П.Цэцгээ **68** удаа оролцсоноос **4**, Ч.Тунгалаг **59** удаа оролцсоноос **5** хэргийг тус тус илтгэж шийдвэрлэсэн байна. Танхимын тэргүүн О.Зандраа **9**, шүүгч Л.Атарцэцэг, Д.Пунцаг, Ч.Тунгалаг нар тус бүр **1** удаа эрүүгийн хэргийн шүүх хуралдааныг даргалжээ.

Хяналтын шатны **иргэний** хэргийн шүүх хуралдаанд Танхимын тэргүүн О.Зандраа **34** удаа оролцсоноос **15** шүүх хуралдааныг даргалж, шүүгч Д.Пунцаг **57**, П.Цэцгээ **54**, Л.Атарцэцэг **48**, Ч.Тунгалаг **40** удаа тус тус оролцжээ. Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг хянуулах хүсэлттэй **3** иргэний хэргийг Захиргааны хэргийн танхимын шүүгч нар шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэсний **2** хэргийг шүүгч Л.Атарцэцэг, **1** хэргийг шүүгч Д.Пунцаг тус тус илтгэсэн байна.

2006 онд Захиргааны хэргийн танхим шүүгчийн захирамж **12**-ыг гаргаснаас гомдол гаргаагүйд тооцох тухай **8**, шүүх хуралдааныг хойшлуулах тухай **4** захирамж, шүүхийн тогтоол **24** гаргаснаас гомдол гаргаагүйд тооцох тухай **1**, шүүх хуралдааныг хойшлуулах тухай **19**, шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас гаргасан хүсэлтийг хангахаас татгалзах тухай **2**, шүүгчийг татгалзан гаргах хүсэлтийг шийдвэрлэх тухай **2** шүүхийн тогтоол байна. Танхимын тэргүүн нийт **311** захирамж гаргаснаас **286** нь шүүх бүрэлдэхүүнийг томилох тухай, **21** нь харьяалал тогтоох тухай, **4** нь захиргааны хэргийг шижүүлэх тухай захирамж байв.

Захиргааны хэргийн танхимд нийт **41** байгууллага, албан тушаалтнаас албан бичиг ирүүлсэнд Танхимын тэргүүн болон шүүгч нар зохих хариуг албан бичгээр өгч, Танхимын тэргүүн О.Зандраа **20** иргэдийн өргөдөл, гомдлыг шийдвэрлэжээ.

### **Хоёр. Мэргэжлийн удирдлагаар хангах ажиллагааны талаар**

Шүүх, шүүгчдийг мэргэжлийн удирдлагаар хангах үндсэн арга зам нь шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх нэгдсэн бодлого боловсруулах, хуулийг нэг мөр ойлгон, зөв хэрэглэх талаар хуулийн албан ёсны тайлбар гаргах, шүүх, шүүгчдийн ажлыг шалган туслаж, тэдний дунд сургалт зохион байгуулах явдал юм.

Тайлангийн хугацаанд Улсын Дээд шүүх хуулийн зүйл, заалтыг тайлбарласан нийт **27** тайлбар гаргаж, “Дээд шүүхийн мэдээлэл”, “Төрийн мэдээлэл” сэтгүүлүүдэд нийтлүүлж, олон нийтийн хүртээл болголоо. Үүнд:

1. “Эрүүгийн хуулийн 49 дүгээр зүйл /эд хөрөнгө хураах/-ийг нэг мөр ойлгож, зөв хэрэглэх тухай” /Шүүгч С.Нямжав/
2. “Улсын Дээд шүүхийн 2003 оны 23 дугаар тогтоолд өөрчлөлт оруулах тухай” /Танхимын тэргүүн Д.Батсайхан/
3. “Эрүүгийн хуулийн 181 дүгээр зүйлийн 181.3 дахь хэсгийн зарим заалтыг тайлбарлах тухай” /Танхимын тэргүүн Д.Батсайхан/
4. “Автотээврийн тухай хуулийн зарим зүйл, хэсэг, заалтыг тайлбарлах тухай” /Танхимын тэргүүн Ц.Амарсайхан/
5. “Эмийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн зарим заалтыг тайлбарлах тухай” /Шүүгч А.Доржготов/
6. “Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн зарим зүйл, хэсэг, заалтыг тайлбарлах тухай” /Шүүгч Д.Тунгалаг/
7. “Шүүхийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.3 дахь хэсгийн зарим заалтыг тайлбарлах тухай” /Танхимын тэргүүн О.Зандраа/
8. “Эрүүгийн хуулийн 60 дугаар зүйлийг тайлбарлах тухай” /Шүүгч Б.Доржготов/
9. “Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 326 дугаар зүйлийн 326.1, 353 дугаар зүйлийн 353.4 дэх хэсгийг тайлбарлах тухай” /Шүүгч Б.Бат-Эрдэнэ/
10. “Улсын хилийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 4 дэх хэсгийг тайлбарлах тухай” /Шүүгч Д.Тунгалаг/
11. “Шүүхийн шийдвэрийн тухай” /Танхимын тэргүүн Ц.Амарсайхан, Д.Батсайхан, О.Зандраа/
12. “Эрчим хүчний тухай хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай” /Шүүгч А.Доржготов/

13. “Эрүүгийн хуулийн 24 дүгээр бүлгийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай” /Танхимын тэргүүн Д.Батсайхан/
14. “Эрүүгийн хуулийн 145 дугаар зүйлийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай” /Танхимын тэргүүн Д.Батсайхан, шүүгч Ч.Ганбат/
15. “Өршөөл үзүүлэх тухай хуулийн зарим зүйл, хэсгийг хэрэглэх тухай” /Танхимын тэргүүн Д.Батсайхан, шүүгч Ч.Ганбат/
16. “Хөдөлмөрийн тухай хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай” /Шүүгч Д.Тунгалаг, Б.Ундрах/
17. “Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.18, 9.2.19 дахь заалтыг тайлбарлах тухай” /Шүүгч А.Доржготов/
18. “Шүүхийн шийдвэр биелүүлэх тухай хуулийн зарим зүйл заалтыг тайлбарлах тухай” /Танхимын тэргүүн О.Зандраа/
19. “Аж ахуйн нэгжийн тусгай зөвшөөрлийн тухай хуулийн зарим зүйл заалтыг тайлбарлах тухай” /Танхимын тэргүүн О.Зандраа/
20. “Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай” /Шүүгч Д.Пунцаг/
21. “Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 44 дүгээр бүлгийн зарим зүйл, заалт, Иргэний хуулийн 498 дугаар зүйлийг тайлбарлах тухай” /Танхимын тэргүүн Д.Батсайхан, Ц.Амарсайхан/
22. “Хүүхдэд мөнгөн тусламж олгох, гэр бүлд тэтгэмж үзүүлэх тухай” хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай /Шүүгч Л.Бямбаа/
23. “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай” /Шүүгч П.Цэцгээ/
24. “Улс төрийн намын тухай хуулийн зарим зүйл заалтыг тайлбарлах тухай” /Шүүгч Д.Тунгалаг/
25. “Бусдын эд хөрөнгийг залилан мэхэлж авах гэмт хэргийг Иргэний эрх зүйн гэрээний харилцаанаас үүссэн маргаанаас ялгаж, зөв зүйлчлэхэд анхаарах зарим ойлголтыг тайлбарлах тухай” /Шүүгч С.Нямжав/
26. “Банкны тухай болон банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль тогтоомжийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай” /Шүүгч А.Доржготов, Л.Бямбаа/
27. “Зээл тооцооны үүргийн талаархи хууль тогтоомжийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай” /Шүүгч А.Доржготов, Л.Бямбаа/

Эдгээр тайлбарууд нь нийгмийн олон талт харилцааг хуулийн хүрээнд зохицуулах, хуулийг нэг мөр ойлгож, зөв хэрэглэх, эрх зүйн шинжлэх ухааны хөгжилд зохих хувь нэмэр оруулж байгаа гэдэгт итгэл төгс байна.

Улсын Дээд шүүхийн эрүүгийн хэргийн танхим **9** тойм, **1** зөвлөмж, иргэний хэргийн танхим **4** тойм, **4** зөвлөмж, захиргааны хэргийн танхим **4** тойм, **2** зөвлөмж, нийт **17** тойм, **7** зөвлөмж гарган шүүхүүдэд хүргүүлснээс гадна “Дээд шүүхийн Мэдээлэл” сэтгүүлд хэвлүүллээ.

Ерөнхий шүүгч С.Батдэлгэр танхимын тэргүүнүүд, Ерөнхий зөвлөлийн Гүйцэтгэх нарийн бичгийн дарга, Тамгын газрын дарга нарын хамт Сүхбаатар, Хэнтий, Дархан-Уул, Сэлэнгэ, Булган, Орхон, Ховд, Баян-Өлгий, Увс, Өмнөговь, Дундговь, Говьсүмбэр, Дорноговь гэсэн **13** аймгуудын шүүхийн ажил байдалтай газар дээр нь очиж танилцан шүүгч, ажилтнуудтай уулзаж, шүүн таслах ажиллагааны чанар үр нөлөө, шүүгч, ажилтны ёс зүй, сахилга хариуцлагыг дээшлүүлэх, ажлын зохион байгуулалт, дотоодын хяналт, шалгалтыг сайжруулах талаар үүрэг даалгавар өгч, тэдгээрийн санал бодол, хүсэлтийг сонсож, зарим асуудлуудыг газар дээр нь шийдвэрлэлээ.

Эрүүгийн хэргийн танхимын Тэргүүн Д.Батсайхан, шүүгч Б.Ундрах, П.Цэцгээ нар Архангай, Иргэний хэргийн танхимын Тэргүүн Ц.Амарсайхан, шүүгч Б.Бат-Эрдэнэ, Л.Атарцэцэг нар Өмнөговь, Захиргааны хэргийн танхимын Тэргүүн О.Зандраа, шүүгч Д.Тунгалаг, Ч.Ганбат нар Говьсүмбэр, шүүгч Ч.Тунгалаг, А.Доржготов, С.Нямжав нар Орхон, шүүгч Д.Пунцаг, Л.Бямбаа нар Хэнтий, Танхимын тэргүүн Д.Батсайхан, Ц.Амарсайхан, О.Зандраа нар Увс аймгийн шүүхийн ажлыг шалган туслаж, мэргэжлийн удирдлагаар хангаж, сургалт зохион байгууллаа.

Мөн шүүгч Б.Бат-Эрдэнэ, Б.Ундрах, Судалгааны төвийн захирал Б.Дангаасүрэн, Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах албаны дарга М.Дамирансүрэн нар шүүхийн шийдвэр бичих аргачлал, шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааны талаар нийслэл, орон нутгийн зарим шүүх болон холбогдох хуулийн байгууллагуудад сургалт зохион байгуулсан байна.



Улсын Дээд шүүх, Хууль зүйн Үндэсний төв, Япон улсын “Жайка” олон улсын байгууллагын “Эрх зүйн шинэтгэл, туслалцаа” төсөл хамтран “**Иргэний хэргийн шийдвэрийн эмхтгэл**”-ийн 2, 3, 4 дүгээр боть, АНУ-ын “Шүүх эрх мэдлийн шинэтгэлийн хөтөлбөр” төсөлтэй хамтран “**Эрүүгийн хэргийн шийдвэрийн эмхтгэл**”-ийн 1, 2, 3 дугаар ботийг тус тус хэвлүүлж, нийтийн хүртээл болголоо.

Улсын Дээд шүүхийн Нийт шүүгчдийн **хуралдаанаар** Архангай, Говьсүмбэр, Орхон, Өмнөговь, Хэнтий аймгуудын шүүх, тэдгээрийн харъяа сум дундын шүүхийн ажлыг шалган тусалсан тухай асуудлыг нэгтгэн хэлэлцэж **1 тогтоол**, Увс аймгийн шүүхийн ажлыг шалган тусалсан тухай асуудлыг хэлэлцэн **1 тэмдэглэлийг** тус тус гарган холбогдох шүүхүүдэд нь хүргүүлээ.

### **Гурав. Тамгын газрын ажлын талаар**

Тамгын газар нь Шүүхийн тухай, Төрийн албаны тухай, Хөдөлмөрийн тухай, Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хууль болон тэдгээрт нийцүүлэн гарсан дүрэм, журам, заавар, Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Шүүхийн Ерөнхий зөвлөлөөс өгсөн үүрэг, даалгаврыг цаг хугацаанд нь биелүүлэх, шүүгч, ажилтнуудын хэвийн ажиллах нөхцлийг хангах, нэгдсэн төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг хугацаанд нь хийж гүйцэтгэх талаар анхааран ажиллаж иржээ.

Тамгын газрын даргын зөвлөл **6** удаа хуралдаж, уг зөвлөлийн хуралдаанаар Улсын Дээд шүүхийн жилийн эцсийн тооллогын дүн, тамгын газрын зарим ажилтнуудад чөлөө олгох, цалинг нь урьдчилан олгох, эрүүл мэндийн болон амьдралын хүнд байдал, ар гэрт нь хөрөнгө мөнгөний гачигдал тохиолдсон ажилтнууд, ахмадын зөвлөлийн гишүүдэд буцалтгүй тусламж олгох, эрхэлсэн ажилдаа хариуцлагагүй хандаж, сахилгын зөрчил дутагдал гаргасан, ажил тасалсан зарим ажилтнуудад сахилгын шийтгэл ногдуулах зэрэг нийт **20** гаруй асуудлыг хэлэлцэн, Ерөнхий шүүгчтэй зөвшилцөн шийдвэрлэжээ.

Тамгын газрын дарга хуульд заасан бүрэн эрхийнхээ хүрээнд Ерөнхий шүүгчтэй зөвшилцөн нийт **93** тушаал гаргасан байна.

Улсын Дээд шүүх энэ онд нийт **662** өргөдөл гомдол, **922** албан бичиг, **2040** хэрэг хүлээн авч, зохих журмын дагуу компьютерт бүртгэн, бүртгэл хяналтын карт нээн, Ерөнхий шүүгчид танилцуулсны дагуу шүүгч, ажилтнуудад хуваарилан өгч шийдвэрлүүлсэнээс гадна **3741** албан бичигт дугаар өгч холбогдох шүүх, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад явуулжээ.

Ерөнхий шүүгч Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах албаны дарга, Бичиг хэрэг, өргөдөл гомдол хариуцсан ахлах зааварлагчийг байлцуулан **9** удаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын төлөөлөгч нийт **119** хүнтэй биечлэн уулзаж, санал хүсэлтийг нь сонсон, зохих хариуг өгчээ.

Шүүх болон шүүгч нарыг мэргэжлийн удирдлагаар хангах, орон нутагт иргэдийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, шүүгч, ажилтнуудынхаа ажиллах нөхцлийг сайжруулах талаар хийж байгаа ажлын талаар сар бүр мэдээлэл авч, Ерөнхий шүүгчид танилцуулж, улмаар уг мэдээллийг нэгтгэн нийт шүүхийн Ерөнхий шүүгч нарт хүргүүлж байгаа нь шүүхийн удирдлага бусад шүүхийн хийсэн ажлаас санаа авч ажлаа уялдуулан сайжруулахад зохих үр дүн өгч байна.

Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах алба шүүх, шүүгчийн үйл ажиллагаатай холбоотой **257** мэдээ, нийтлэл гарсныг бүртгэн, Ерөнхий шүүгчид тухай бүр нь танилцуулан холбогдох арга хэмжээг авч, үндэслэл муутай мэдээ, нийтлэлийг няцаах зорилгоор **6** хариу тайлбар, залруулгыг өдөр тутмын сонинуудад нийтлүүлжээ.

### **Шүүх эрх мэдлийн байгууллагын мэдээллийн төвд:**

- “2006 оны шүүн таслах ажиллагааны талаарх мэдээлэл”;
- “Шүүн таслах үйл ажиллагаанд өмгөөлөгчдийн үүрэг роль”;
- “Онц хүнд гэмт хэрэг үйлдэгсдэд шүүхээс оногдуулж байгаа ял шийтгэл”-ийн талаар;
- “Хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтлэгдсэн шүүхтэй холбоотой материалтай холбогдуулан шүүхээс хийж байгаа ажлын талаар”;

- “Нийслэлийн шүүхийн 2006 оны эхний 5 сард шийдвэрлэсэн эрүүгийн хэргийн байдлын талаар”;
- “Нийслэлийн шүүхийн үйл ажиллагааны талаар”;
- “Сүхбаатар дүүргийн шүүхийн 2006 оны эхний 6 сарын эрүү, иргэний хэргийн шийдвэрлэлтийн байдлын талаар”;
- “Монгол Улсын Шүүхийн хагас жилийн мэдээ, тайлан”;
- “Гаалийн Ерөнхий газрын дарга асан Х.Баатар нарын 10 хүнд холбогдох албан тушаалаа урвуулан ашиглаж их хэмжээний авилга авсан, хилээр хууль бусаар эд зүйл гаргасан хэргийн талаар”;
- “Шүүхээс 2006 оны 7 дугаар сараас 10 дугаар сар хүртэлх хугацаанд шийдвэрлэгдсэн болон хянагдаж байгаа онц хүнд гэмт хэргийн талаар”, “Шүүхийн боловсон хүчний талаар”;
- “2006 оны 11 сарын байдлаар Улсын Дээд шүүхэд хянагдаж буй онц хүнд гэмт хэрэг болон олны анхаарлыг татаж буй Хадгаламж, зээлийн хоршоодын хэргийг анхан шатны шүүхэд шийдвэрлэж буй байдлын талаар” тус тус хэвлэлийн бага хурал зохион байгуулж, мэдээлэл хийв.

Байгууллагын номын санд **104** ширхэг номыг худалдан авсны дотор Үндсэн хуулийн эрх зүйн **10**, Эрүүгийн эрх зүйн **24**, Иргэний эрх зүйн **22**, Хөдөлмөрийн эрх зүйн **20**, Олон Улсын эрх зүйн **1**, Төр эрх зүйн **11**, Монголын түүхийн **5**, Хүний эрхийн чиглэлийн **24** болон бусад ном **13** ширхэг байна.

Түүнээс гадна **5** нэрийн **72** ширхэг номыг “Германы техникийн хамтын ажиллагааны нийгэмлэг”, “Соросын сан”, “Шүүх эрх зүйн шинэчлэлт төсөл”, “Олон улсын Барын холбоо”-ноос бэлэглэлээр авчээ.

Архив, номын сан хариуцсан мэргэжилтэн нь **2005** оны баримтуудыг Эрүү, Иргэн, Захиргааны хэргийн танхим, Тамгын газар, Шүүхийн судалгааны төвөөс 2006 оны 1 дүгээр улиралд багтаан хүлээн авч, “Байнгын хадгалах бүртгэл”-ийн дансанд **64**, “Түр хадгалагдах бүртгэл”-ийн дансанд **51** нэгж болгон зохих дансуудад бүртгэн хайрцагласан байна.

**Ерөнхий шүүгчийн ажлын алба** “Улсын Дээд шүүхэд хэрэг болон иргэд, хуулийн этгээд, хэргийн оролцогчдоос гаргасан өргөдөл, гомдлыг хүлээн авах, хуваарилах, шийдвэрлэх журам”, “Ерөнхий шүүгчийн ажлын албаны зорилт гүйцэтгэх үүрэг”-т заасны дагуу Ерөнхий шүүгчийн нэр дээр гаргасан гомдлоор эрүүгийн **81**, иргэний **160**, захиргааны **30**, **нийт 271** хэргийг хүлээн авч, эрүүгийн **4**, иргэний **3**, захиргааны **1** хэргийн тогтоолд хууль зөрчсөн үндэслэлээр тус тус **дүгнэлт** бичиж, **263** хэрэгт хариу өгчээ.

Мөн хэргийн оролцогч **90** хүнийг хүлээн авч уулзаж, холбогдох хариуг өгсөн байна.

Тайлангийн хугацаанд Нийт шүүгчдийн хуралдааны зохион байгуулалтын асуудал хариуцсан шинжээч **С.Соёмбо-Эрдэнэ** Сонгинохайрхан дүүргийн шүүхийн, Эрүүгийн хэргийн танхимын шүүгчийн туслах-шинжээч **Т.Өсөхбаяр** Баянзүрх дүүргийн шүүхийн, Иргэний хэргийн танхимын шүүгчийн туслах-шинжээч **Ц.Оч** Баянгол дүүргийн шүүхийн, Эрүүгийн хэргийн танхимын тэргүүний туслах-шинжээч **М.Алдар** Сүхбаатар дүүргийн шүүхийн, Бичиг хэрэг, өргөдөл гомдол хариуцсан мэргэжилтэн **Т.Оюунханд** Архангай аймгийн захиргааны хэргийн шүүхийн **шүүгчийн албан тушаалд** тус тус дэвшин томилогдож, **Н.Долгорсүрэнг** Гадаад харилцааны асуудал эрхэлсэн зөвлөх-ахлах референтийн, **З.Нацагийг** Ерөнхий шүүгчийн шүүн таслах ажиллагаа хариуцсан референтийн, **Д.Хуланг** Нийт шүүгчдийн хуралдааны зохион байгуулалтын асуудал хариуцсан шинжээчийн, **Ч.Отгонбаяр**, **Ж.Сэмжид** нарыг Иргэний хэргийн танхимын шүүгчийн туслах-шинжээчийн, **Б.Батболорыг** Захиргааны хэргийн танхимын шүүгчийн туслах-шинжээчийн, **Д.Алтанжигүүрийг** Эрүүгийн хэргийн танхимын шүүгчийн туслах-шинжээчийн, **Э.Баярбаатарыг** Компьютер программ хангамжийн асуудал хариуцсан шинжээчийн, **Н.Саранчимэгийг** Хэвлэл мэдээллийн төлөөлөгч-ахлах зааварлагчийн, **Ш.Даваадуламыг** Хууль тогтоомжийн системчлэлийн ажил эрхэлсэн ахлах зааварлагчийн, **Ц.Цэцэгдэлгэрэхийг** Бичиг хэрэг, өргөдөл гомдол хариуцсан зааварлагчийн, **Ө.Уянгыг** Мэдээлэл лавлагаа хариуцсан зааварлагчийн, **Б.Отгонцэрэнг** няравын, **Д.Мөнхнасанг** жолоочийн, **А.Дашжамцыг** санхтехникийн слесарийн, **С.Должинсүрэнг** үйлчлэгчийн, **Б.Энхээг** мужааны ажил, албан тушаалд бүр болон түр хугацаагаар Ерөнхий шүүгчтэй зөвшилцөн Тамгын газрын даргын тушаалаар томилон ажиллуулж байна.

Ерөнхий шүүгчийн ажлын албаны дарга асан **Н.Төрбат**, Хууль тогтоомжийн системчлэлийн ажил эрхэлсэн ахлах зааварлагч **Ё.Цэрэндэжид** нар өөрсдийнхөө хүсэлтээр төрийн албанаас чөлөөлөгдөн, өндөр насны тэтгэвэрт гарлаа.

Тамгын газар Компьютерийн программ хангамж хариуцсан шинжээч **1**, сантехникийн слесарь **1**, бүгд **2** орон тоог Шүүхийн Ерөнхий зөвлөлийн тогтоолоор шинээр нэмж батлууллаа.

Төрийн албаны зөвлөлөөс батласан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-д заасны дагуу Улсын Дээд шүүхэд сул байгаа орон тоонд сонгон шалгаруулалт зарлаж, Төрийн албаны зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн дүгнэлт гаргуулж, **С.Баасанцэрэнг** Санхүү, хангамж, үйлчилгээний албаны, **Ц.Түмэнбаярыг** Дотоод ажил, зохион байгуулалт, хяналтын албаны даргын албан тушаалд тус тус томилон ажиллууллаа.

Төрийн захиргааны албанд түр хугацаагаар томилогдон ажиллаж байсан **Э.Баярбаатар**, **Б.Отгонцэрэн** нар Төрийн албаны тухай хуульд заасны дагуу төрийн захиргааны албаны мэргэшлийн шалгалтанд орж тэнцжээ.

“Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журам”-д заасан болзлыг хангасан Ерөнхий шүүгчийн шүүн таслах ажиллагаа хариуцсан референт **З.Нацагт** “Ахлах түшмэл” ангиллын “АА-6” зэрэглэлийн “**Дэд**”, Ерөнхий шүүгчийн туслах-ахлах шинжээч **И.Ганбат**, Эрүүгийн хэргийн танхимын шүүгчийн туслах-шинжээч **Б.Цогт** нарт “Ахлах түшмэл” ангиллын “АА-8” зэрэглэлийн “**Дөтгөөр**”, Эрүүгийн хэргийн танхимын шүүгчийн туслах-шинжээч **Д.Алтанцэцэг** “Ахлах түшмэл” ангиллын “АА-8” зэрэглэлийн “**Гутгаар**”, Хууль тогтоомжийн системчлэлийн ажил эрхэлсэн ахлах зааварлагч **Ш.Даваадуламд** “Дэс түшмэл” ангиллын “АА-9” зэрэглэлийн “**Гутгаар**” зэрэг дэвийг тус тус олгох шийдвэрлэжээ.

“Төрийн захиргааны албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам”-д заасан болзлыг хангасан Ерөнхий шүүгчийн туслах-ахлах шинжээч **И.Ганбат**, Эрүүгийн хэргийн танхимын шүүгчийн туслах-шинжээч **Б.Цогт**, Иргэний хэргийн танхимын шүүгчийн туслах-шинжээч **Л.Ганзориг**, Захиргааны хэргийн танхимын шүүгчийн туслах-шинжээч **Г.Есөн-Эрдэнэ**, Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны судалгаа хариуцсан шинжээч **Ц.Нарангэрэл**, Хууль тогтоомжийн системчлэлийн ажил эрхэлсэн ахлах зааварлагч **Ш.Даваадулам**, Хэвлэл мэдээллийн төлөөлөгч-ахлах зааварлагч **Н.Саранчимэг**, Архив, номын сан хариуцсан мэргэжилтэн **Ж.Тэгшдэлгэр** нарын төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг шинээр болон нэмэгдүүлэн олголоо.

**Клиникийн Нэгдсэн 2 дугаар эмнэлэг** болон **Төрийн тусгай албан хаагчдын эмнэлэгээр** 2006 онд үйлчлүүлэх шүүгч, ажилтнууд, тэдгээрийн эхнэр, нөхөр, ам бүлд байгаа хүүхдүүдийн судалгааг гарган дээрхи эмнэлэгүүдийн захиргаанд хүргүүлж, байнгын эмчийн хяналт, эмнэлгийн урьдчилсан үзлэгт хамруулах, шаардлагатай тохиолдолд хэвтэн эмчлүүлэх нөхцөл бололцоог хангаж өглөө.

Улсын Дээд шүүхийн шүүгч, ажилтнуудын биеийн эрүүл мэндийн байдал, ажлын ачаалал зэргийг харгалзан “Төрийн тусгай албан хаагчдын эмнэлэг”-т албан бичгээр хүсэлт тавьж 11 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн эмч ажиллуулж байна.

Шүүгч, ажилтнуудын гэр бүлээс их, дээд сургуульд 2006-2007 оны хичээлийн жилд суралцаж байгаа нийт **6** оюутны “Сургалтын төлбөрийг төрөөс хариуцан санхүүжүүлэх тухай” гэрээг Сургалтын төрийн сантай байгуулж, төлбөрийг нь төлж байна.

Төрийн албаны тухай хуульд заасны дагуу ээлжийн амралтаараа өөрийн төрсөн нутагт очиж амарсан шүүгч **Л.Бямбаа**, **С.Нямжав** нарын унааны зардлыг, түүнчлэн ар гэрт нь гачигдал тохиолдсон шүүгч, ажилтан, Ахмадын зөвлөлийн гишүүн **17** хүнд нийт **1 340 000** төгрөгийн буцалтгүй тусламжийг тус тус олгов.

“Ахмадын зөвлөлийн гишүүдийн талаар авах арга хэмжээний тухай журам”-д заасны дагуу Ахмадын зөвлөлийн гишүүн **Ц.Бүжинлхам**, **С.Дашханд**, **Д.Минжүүр** нарын сувилалд амарч сувилуулах эрхийн бичгийн үнийн **50** хувийг олголоо.

Тамгын газрын даргын 2005 оны 111 дүгээр тушаалаар батлагдсан “Халамжийн сан бүрдүүлэх, хадгалах, зарцуулах журам”-д заасны дагуу энэ онд давхардсан тоогоор **26** хүнийг эмнэлэгт эмчлүүлж байх хугацаанд нь **295.000** төгрөгөөр эргэсэн бөгөөд одоо уг санд **410.300** төгрөгийн үлдэгдэл байна.

Засгийн газраас хэрэгжүүлж буй “**40 000 айл орон сууц**” хөтөлбөрт хамруулах зорилгоор Улсын Дээд шүүхийн шүүгч, ажилтнуудын дунд орон сууцны судалгаа явуулж, холбогдох байгууллагад хүргүүлээд байна.

Ойн баяр болон тэмдэглэлт өдрүүдэд Улсын Дээд шүүх дээр сахилга, хариуцлага, дэг журам, сонор сэрэмжийг өндөржүүлэх зорилгоор **5** удаагийн тушаалаар **9** хүнийг хариуцлагатай эргүүлээр томилон ажиллуулжээ.

Сахилга хариуцлага алдсан, ажлын алдаа дутагдал гаргасан **8** ажилтанд Тамгын газрын даргын тушаалаар сахилгын шийтгэл оногдуулж, **1** хүнийг ажлаас халсан байна.

Улсын Дээд шүүхийн “Залуучуудын зөвлөл”-ийн санаачлагаар “Их Монгол Улс байгуулагдсаны 80 жилийн ой”, “Шүүх байгуулагдсаны 80 жилийн ой”-д зориулж, Нийслэл, дүүрэг, Нийслэлийн Захиргааны хэргийн шүүхүүдтэй хамтарч 2006 оны 5 дугаар сарын 20-ны өдөр Улаанбаатар хотын төвд **880** ширхэг мод тарив.

Монгол Улсад Шүүх байгуулагдсаны 80 жилийн ойг тохиолдуулан Сүхбаатар дүүргийн шүүх 5 дугаар сарын 26, 27-ны өдрүүдэд “Нийслэл, дүүргүүдийн шүүхүүдийн шилжин явах цомын төлөө тэмцээн”-ийг сагсан бөмбөг, гар бөмбөг, одон бөмбөгийн төрлөөр зохион байгуулахад Улсын Дээд шүүх амжилттай оролцож, багийн дүнгээр **2** дугаар байр эзэллээ. Хуульч Эмэгтэйчүүдийн холбооноос зохион явуулагдсан “Сагсан бөмбөг”-ийн тэмцээнд манай эмэгтэй баг тамирчид амжилттай оролцон, **1** дүгээр байр эзэлж, “**Шилжин явах цом**” гардан авлаа.

“Бүгд Найрамдах улс” тунхагласны баярыг тохиолдуулан жил бүр хуулийн төв байгууллагуудын дунд зохиогддог “**Шилжин явах цомын төлөө спортын наадам**”-ыг Улсын Дээд шүүх зохион байгуулж, манай баг тамирчид амжилттай оролцож, багаараа **2** дугаар байр эзлэв.

Улсын Дээд шүүхийн Дарга, Ерөнхий шүүгч асан Д.Дэмбэрэлцэрэн БНХАУ руу эмчилгээнд явахад нь мөнгөн тусламж үзүүлэхийг бүх шатны шүүхэд уриалж, **2 сая** гаруй төгрөгийг цуглуулж өглөө.

2006 онд Улсын Дээд шүүхийн төсөв **352,07** сая төгрөгөөр, үүнээс урсгал зардалд **326,37** сая төгрөг, их засварт **15** сая төгрөг, тоног төхөөрөмж худалдан авахад **10,7** сая төгрөг тус тус батлагдсан билээ.

Урсгал зардлын батлагдсан төсвийг бүрэн авч, төсөвт тусган төсвийн зардлыг зохих журмын дагуу зарцуулж, санхүүгийн мэдээ тайланг хугацаанд нь гаргаж ирлээ.

Урсгал зардлын төсвийг хэрхэн зарцуулсныг зүйл тус бүрээр нь танилцуулбал:

- Бичиг хэрэг, аж ахуйн зардалд **6.964,3** мянган төгрөг төлөвлөснөөс **6.962,14** мянган төгрөг зарцуулагдсан бөгөөд **2,16** мянган төгрөгөөр хэмнэсэн;
- Гэрэл цахилгааны зардалд **4.458,5** мянган төгрөг төлөвлөснөөс **4.313,33** мянган төгрөг зарцуулагдаж, **145,17** мянган төгрөгөөр хэмнэсэн;
- Түлш, халаалтын зардалд **15.959,6** мянган төгрөг төлөвлөснөөс **10.241,26** мянган төгрөг зарцуулагдаж, **5.718,34** мянган төгрөгөөр хэмнэгдсэн;
- Тээвэр, шатахууны зардалд **10.510,3** мянган төгрөг төлөвлөснөөс **14.009,45** мянган төгрөг зарцуулж, **3.499,15** мянган төгрөгөөр хэтэрсэн;
- Шуудан, холбооны зардалд **14.651,8** мянган төгрөг төлөвлөснөөс **15.297,4** мянган төгрөг зарцуулагдаж, **645,6** мянган төгрөгөөр хэмнэсэн;
- Цэвэр, бохир усны зардалд **1.725,6** мянган төгрөг төлөвлөснөөс **607,4** мянган төгрөг зарцуулагдаж, **1.118,2** мянган төгрөг хэмнэгдсэн;
- Дотоод албан томилолтын зардалд **4.755,4** мянган төгрөг төлөвлөснөөс **4.636,9** мянган төгрөг зарцуулагдаж, **118,5** мянган төгрөгөөр хэмнэсэн;

- Гадаад албан томилолтын зардалд **5.320,0** мянган төгрөг төлөвлөснөөс **3.476,6** мянган төгрөг зарцуулагдаж, **1.843,4** мянган төгрөгөөр хэмнэсэн;
- Ном, хэвлэл авах зардалд **2.110,0** мянган төгрөг төлөвлөснөөс **2.019,63** мянган төгрөг зарцуулагдаж, **90,37** мянган төгрөгөөр хэмнэсэн;
- Нормын хувцас авах зардалд **127,5** мянган төгрөг төлөвлөгдсөнөөс **75,2** мянган төгрөг зарцуулж **52,3** мянган төгрөг хэмнэсэн;
- Урсгал засварын зардалд **2.333,3** мянган төгрөг төлөвлөгдсөнөөс **3.604,39** мянган төгрөг зарцуулагдаж, **1.271,09** мянган төгрөгөөр хэтэрсэн;
- Гадаад зочны зардалд **5.100,00** мянган төгрөг төлөвлөснөөс **4.554,08** мянган төгрөг зарцуулж **545,92** мянган төгрөг хэмнэгдсэн;
- Ерөнхий шүүгчийн байрны зардалд **303,2** мянган төгрөг төлөвлөгдсөнөөс **152,2** мянган төгрөг зарцуулагдаж, **151,0** мянган төгрөгөөр хэмнэгдсэн;
- 1 удаагийн тэтгэмж, урамшууллын зардалд **11.337,2** мянган төгрөг төлөвлөснөөс **14.790,05** мянган төгрөг зарцуулагдаж, **3.452,8** мянган төгрөгөөр хэтэрсэн;
- Төлбөр хураамж болон бусад зардалд **4.457,7** мянган төгрөг төлөвлөгдсөнөөс **4.457,7** мянган төгрөг зарцуулсан;
- Ажил олгогчоос нийгмийн даатгалын шимтгэлд **46.864,5** мянган төгрөг төлөвлөснөөс **46.724,07** мянган төгрөг зарцуулагдаж, **140,4** мянган төгрөгөөр хэмнэгдсэн;
- Цалин хөлс, нэмэгдлийн зардалд **175.732,2** мянган төгрөг төлөвлөгдсөнөөс **174.173,62** мянган төгрөг зарцуулагдаж, **1.558,8** мянган төгрөг хэмнэгдсэн;
- Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийхэд **12.660,0** мянган төгрөг батлагдсанаас **13.144,78** мянган төгрөг зарцуулагдаж, **484,78** мянган төгрөгөөр хэтэрсэн;
- Жижиг эд хогшил худалдан авах зардалд **1.000,0** мянган төгрөг батлагдсанаас **1.051,99** мянган төгрөг тус тус зарцуулсан байна.

“Эрх зүйн боловсрол академи”-д 3 өрөөг түрээслэн нийт **4.194.000** төгрөгийн орлого олсноос Улсын Дээд шүүхийн конторын барилгын их засварын ажилд болон “Шинэ жил”, “Цагаан сар”, “Эмэгтэйчүүдийн баяр”, “Хүүхдийн баяр”, “Ахмадын өдөр”-ийг тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээ зэрэгт зарцуулж, үлдэгдэл мөнгөгүй болсон байна.

Эрүү, Иргэний хэргийн танхимын тэргүүний “Соната-5” маркийн тус бүр нь **14 сая** төгрөгийн үнэ бүхий автомашиныг ТӨХ-ны 559 дүгээр тогтоолын дагуу Нийслэлийн **Сонгинохайрхан дүүрэг, Дархан-Уул аймгийн шүүхэд**, 638 дугаар тогтоолын дагуу **7.907.939** төгрөгийн үнэ бүхий **5** ширхэг Dell маркийн компьютерийг **Завхан, Өвөрхангай, Ховд, Сэлэнгэ аймгийн сум дундын 2, 3 дугаар** шүүхүүдэд балансаас балансад шилжүүлэн өглөө.

Засгийн газрын нөөц хөрөнгөнөөс **65.1 сая**, Улсын Дээд шүүхийн төсвөөс **1.8 сая** төгрөг гарган Эрүү, Иргэн, Захиргааны хэргийн танхимын тэргүүний албан ажлын хэрэгцээнд зориулж, “Соната-6” маркийн автомашиныг нээлттэй тендэр зарлан худалдаж авлаа.

Энэ онд байгууллагаа тохижуулах, шүүгч, ажилтнуудын ая тухтай ажиллах нөхцлийг хангахад ихээхэн анхаарч ажиллаа.

Тендер зарлан Улсын Дээд шүүх, Шүүхийн Ерөнхий зөвлөлийн хөрөнгө оруулалтын төсвийн хөрөнгөөр конторын барилгын их засварын ажлыг “Хүрээ барилга”, “Тэрхтрейд”, “Дөрвөн ивээл”, “Зууны интерьер” ХХК-иар гүйцэтгүүлээ.

Монгол Улсад шүүх байгуулагдсны 80 жилийн ойг тохиолдуулан бусад байгууллагаас Улсын Дээд шүүхэд бэлэглэсэн дурсгалын зүйлийг нэг бүрчлэн үндсэн хөрөнгөд бүртгэж, бэлэглэсэн зургуудыг 1-4 давхарын коридорт байрлуулж, 2 ширхэг хэвлэгч болон хувилагч хос ажиллагаат машиныг албан ажлын хэрэгцээнд зориулан холбогдох ажилтнуудад өглөө.

Тооллогын комисс нь **21** хоногийн хугацаанд байгууллагын жилийн эцсийн эд хөрөнгийн тооллогыг шүүгч, ажилтнуудын эзэмшиж байгаа эд хөрөнгө, шүүх хуралдааны танхим, коридор, вестибюльд байгаа эд зүйлсийг хариуцсан ажилтнуудын карттай нь, агуулахад хадгалагдаж байгаа эд зүйлсийг үлдэгдлээр нь бүртгэлтэй тулган тоолсон байна.

Байгууллагын дүнгээр **367.275.483** төгрөгийн үнэ бүхий үндсэн хөрөнгө, **9.156.670** төгрөгийн үнэ бүхий бичиг хэрэг, аж ахуйн материал, **184.207.820** төгрөгийн үнэ бүхий **8** автомашин тоологдлоо.

### **Дөрөв. Шүүхийн судалгааны төвийн ажлын талаар**

Улсын Дээд шүүхийн дэргэдэх шүүхийн Судалгааны төв нь эрүү, иргэн, захиргааны хэргийн шүүн таслах ажиллагааны мэдээг хагас болон бүтэн жил, улиралаар гаргаж, Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгч, танхимын тэргүүнүүдэд тухай бүр танилцуулж, Монгол Улсын хууль, Улсын Их Хурлын тогтоол, Засгийн газрын тогтоол, бусад эрх зүйн актыг шүүхийн нэгдсэн санд оруулах, нэмэлт өөрчлөлтүүдийг тухай бүр хийх, шүүн таслах ажиллагааны зарим тулгамдсан асуудлаар тойм, зөвлөмж гаргах зэрэг үндсэн ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна.

2006 онд Улсын Дээд Шүүхэд хяналтын журмаар хянагдсан эрүү, иргэн, захиргааны хэргийн тогтоол, шийдвэр, магадлал өөрчлөгдсөн, хүчингүй болсон шалтгааныг судалж улирал бүр тойм бичиж, аймаг, нийслэл, нийслэлийн захиргааны хэргийн шүүхүүдэд хүргүүлжээ.

Хүнд, онц хүнд гэмт хэрэг үйлдэгсдэд оногдуулсан ялыг 2003-2005 оны байдлаар судалж, тойм бичиж нийт шүүхүүдэд хүргүүлсэн ба Дээд шүүхийн мэдээлэл сэтгүүлд нийтлүүлэв.

Албан тушаал, хээл хахуулийн гэмт хэрэг үйлдэгчдэд оногдуулсан ялыг 2003-2005 оны байдлаар судалж, УИХ-ын Хууль зүйн байнгын хороо, Авилгатай тэмцэх хууль боловсруулах ажлын хэсэгт хүргүүлсэн байна.

Шүүхийн мэдээлэлийн нэгдсэн санд 2006 онд шинээр батлан гаргасан хууль **25**, олон улсын гэрээ **14**, хуулийн нэмэлт, өөрчлөлт **74**, Улсын Их Хурлын тогтоол **88**, Засгийн газрын тогтоол **64**, Ерөнхийлөгчийн зарлиг **45**, Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн хэм хэмжээ тогтоосон захирамж **6**, тойм, зөвлөмж **19**, шүүн таслах ажиллагааны практик тогтоосон эрүүгийн **89**, иргэний **121**, захиргааны **54**, Дээд шүүхийн нийт шүүгчдийн хуралдааны **12** тогтоол, шийдвэрийг оруулжээ.

Бүх шатны шүүхийн шүүн таслах ажиллагааны 2005, 2006 оны статистик мэдээг нэгтгэн улсын хэмжээний нэгдсэн дүнг гарган, танилцуулгыг Улсын Дээд шүүхийн удирдлага, Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд болон бүх шатны шүүхүүдэд хүргүүлэн танилцуулжээ.

Аймаг, Нийслэл, дагнасан болон сум буюу сум дундын, дүүргийн шүүх, шүүгчдийн ажлыг 2005 оны байдлаар дүгнэж шалгаруулан байр эзлүүлж, Улсын Дээд шүүхийн удирдлагад танилцуулав. “Монгол Улсын шүүхийн шийдвэрийн эмхэтгэл” номын 2, 3, 4, 5 дугаарт орох эрүү, иргэн, захиргааны хэргийн шийдвэр, магадлал, тогтоолуудаас сонголт хийж, Хууль зүйн үндэсний төвд хүргүүлснээс гадна эдгээр эмхэтгэлийн эх хувийг хянах ажиллагааг гүйцэтгэв.

Шүүхээс оргон зайлсан шүүгдэгчдийн судалгааг сүүлийн 10 жилээр гаргаж Эрүүгийн цагдаагийн газарт хүргүүлжээ.

“Монголын төр эрх зүй”, “Дээд шүүхийн мэдээлэл” сэтгүүлийн тус бүр **4** дугаарыг эрхлэн хэвлүүлжээ.

### **Тав. Гадаад арга хэмжээний талаар**

Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн урилгаар БНХАУ-ын Ардын Дээд шүүхийн дарга, Хятадын тэргүүлэгч их шүүгч, ноён **Шао Ян** тэргүүтэй төлөөлөгчид 2006 оны 4 дүгээр сарын 5-7-ны өдрүүдэд Монгол Улсад албан ёсны айлчлал хийлээ.

Энэхүү айлчлалын үеэр цаашид хоёр орны шүүхийн харилцаа, хамтын ажиллагааг гүнзгийрүүлэн хөгжүүлэх, харилцан туршлага солилцох, Монголын шүүхийн тодорхой тооны шүүгчдийг жил бүр БНХАУ-ын Ардын Дээд шүүхийн дэргэдэх “**Шүүгчдийг давтан сургах төв**”-д сургалтад хамруулах зэрэг асуудлыг хэлэлцэн тохиролцов.

**АНУ-ын** Техас муж улсын Уэслианы их сургуулийн Азийн сургалтын төвд 6 дугаар сарын 17-ноос 7 дугаар сарын 01-ний хооронд Улсын Дээд шүүхийн шүүгч Б.Бат-Эрдэнэ, Орхон аймгийн

шүүхийн Ерөнхий шүүгч П.Батсайхан, Нийслэлийн шүүхийн шүүгч З.Цэнгэнбаяр, Баянгол дүүргийн шүүхийн шүүгч Х.Эрдэнэсүвд, Чингэлтэй дүүргийн шүүхийн шүүгч С.Оюунгэрэл, Завхан аймгийн Сум дундын 1 дүгээр шүүхийн Ерөнхий шүүгч Д.Ням, Увс аймгийн шүүхийн шүүгч Ч.Дулмаа, Сүхбаатар аймгийн шүүхийн шүүгч Д.Байгалмаа, Ерөнхий прокурорын туслах, Мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавих хэлтсийн дарга Л.Болд нар АНУ-ын шүүхийн тогтолцоо, үйл ажиллагаатай танилцаж, туршлага судлав.

Иргэний хэргийн танхимын тэргүүн Ц.Амарсайхан **БНХАУ-ын** Шинжаан Уйгарын өөртөө засах орны Үрэмч хотноо 2006 оны 8 дугаар сарын 11-нээс 14-ний хооронд зохион байгуулагдсан “Бүсийн хуулийн байгууллагуудын хамтын ажиллагааны форум” сэдэвт хуралд оролцов.

Эрүүгийн хэргийн танхимын тэргүүн Д.Батсайхан **Швед** улсын Стокгольм хотноо 2006 оны 9 дүгээр сарын 02-ноос 12-ны хооронд зохион байгуулагдсан “Олон улсын Эрүүгийн хамтын ажиллагаа” сэдэвт сургалт семинарт оролцов.

Шүүгч Б.Бат-Эрдэнэ НҮБ-ын “Хүүхдийн хөгжлийн сан”-гийн шугамаар **Тайланд** улсад “Хүүхдийн эрхийг хамгаалах” сэдэвт бага хуралд оролцож, ял хойшлуулсан, тэнссэн хүүхдийг нийгэмшүүлэх талаар тус улсын шүүх болон орон нутгийн байгууллагын хийж буй үйл ажиллагаа, туршлагатай танилцлаа.

Шүүгч Б.Ундрах 10 дугаар сарын 2-ны өдрөөс 9-ний хооронд **Киргизстан** улсад зохион байгуулагдсан “Төв азийн шүүгчдийн мэргэжлийн үр чадварыг дээшлүүлэх” семинарт оролцлоо.

11 дүгээр сарын 3-наас 10-ны өдрүүдэд Шүүгчдийн холбооны Гүйцэтгэх захирал М.Дамирансүрэн **АНУ-ын** Нью-Йорк хотод болсон Хойт Америк, Ази, далайн бүсийн орнуудын шүүгчдийн холбооны хуралд оролцсон байна.

Шүүгч Б.Ундрах 11 дүгээр сарын 2-ноос 17-ний өдрүүдэд **БНСУ-ын** Дээд шүүхээс зохион байгуулсан “Шүүхийн шударга ёс ба шүүхийн захиргааны үр нөлөөг дээшлүүлэх нь” сэдэвт сургалтад оролцлоо.

**БНХАУ-ын** Ардын Дээд шүүхийн дарга, Хятадын тэргүүлэгч их шүүгч Шао Яны урилгаар Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгч С.Батдэлгэр, шүүгч Л.Бямбаа, Тамгын газрын дарга Д.Эрдэнэчулуун, Дотоод ажил зохион байгуулалт, хяналтын албаны дарга Ц.Түмэнбаяр, Нийслэлийн шүүхийн Ерөнхий шүүгч Ц.Зориг, Хөвсгөл аймгийн шүүхийн Ерөнхий шүүгч З.Хосбаяр, Говь-Алтай аймгийн шүүхийн Ерөнхий шүүгч А.Насандэлгэр, Баянзүрх дүүргийн шүүхийн Ерөнхий шүүгч Ё.Цогтзандан нар Бээжин хотноо 11 дүгээр сарын 11-нээс 17-ны өдрүүдэд албан ёсны айлчлал хийв.

Айлчлалын хүрээнд хоёр орны шүүхүүдийн харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх, харилцан туршлага солилцох, шүүгчдийг давтан сургах, орон нутгийн шүүхүүдийн харилцааг шинээр болон сэргээн тогтоох, тухайн орнуудад шүүгчдээ харилцан амрах зэрэг асуудлыг хэлэлцэж, энэ чиглэлээр цаашид хамтран ажиллахаар тохиролцож, ирэх оны 5 дугаар сараас эхлэн **25** шүүгчийг **14** хоногийн хугацаатайгаар БНХАУ-д сургахаар боллоо.

**Тайваньд** 11 дүгээр сарын 12-ноос 26-ны хооронд зохион байгуулагдсан шүүгчдийн сургалтад Улсын Дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимын Тэргүүн О.Зандраа, Нийслэлийн шүүхийн шүүгч Ц.Ичинхорлоо, Сүхбаатар дүүргийн шүүхийн шүүгч Г.Алтанчимэг, Баянзүрх дүүргийн шүүхийн шүүгч Ц.Батхүү, Архангай аймгийн шүүхийн шүүгч С.Пүрэвсүрэн, Баянхонгор аймгийн шүүхийн шүүгч Г.Уламбаяр, Ховд аймгийн сум дундын 1 дүгээр шүүхийн Ерөнхий шүүгч Т.Цэцэгмаа, Хэнтий аймгийн сум дундын 1 дүгээр шүүхийн Ерөнхий шүүгч Б.Дэнсмаа, Өмнөговь аймаг дахь сум дундын шүүхийн шүүгч Х.Гэрэлмаа, Дархан-Уул аймгийн сум дундын шүүхийн шүүгч Д.Оюунчимэг нар оролцлоо.

Шүүгч А.Доржготов, гадаад харилцааны асуудал эрхэлсэн зөвлөх-ахлах референт Н.Долгорсүрэн нар 2006 оны 12 дугаар сарын 2-ноос 13-ны хооронд **БНЭУ-ын** Лакнау хотноо зохион байгуулагдсан “Дэлхийн дахины Ерөнхий шүүгчдийн олон улсын бага хурал”-д оролцов.

Түүнчлэн Ерөнхий шүүгч Дэлхийн банкны “Шүүх, эрх зүйн шинэтгэл” төслийн удирдагч Карлос Эскудеро, тус төслийн ажилтан Роберт Бургентель, Ровена Гроспе нарыг хүлээн авч

уулзан цаашид уг төслийн үйл ажиллагааг үргэлжлүүлэх, Улсын Дээд шүүхийг ордонтой болгох талаар тохиролцоонд хүрч чадсныг тэмдэглэн хэлэхэд таатай байна.

Их Монгол Улс байгуулагдсаны 800 жилийн ойн баярт Монгол Улсын Ерөнхийлөгчийн урилгаар оролцсон ОХУ-ын Ерөнхийлөгчийн хуулийн бодлогын зөвлөх Яковлев Вениамин Федорович тэргүүтэй төлөөлөгчид, Үндсэн хуулийн цэцийн даргын урилгаар Монгол Улсад албан ёсны айлчлал хийсэн ОХУ-ын Үндсэн хуулийн цэцийн дарга В.Д.Зорькин тэргүүтэй зочид төлөөлөгчдийг хүлээн авч уулзан, шүүхийн үйл ажиллагааны талаар харилцан санал солилцов.

Мөн ХБНГУ-ын Ханнс-Зайделийн сангийн тэргүүн, төрийн сайд асан Ханс Цэетмайер, Тэргүүн дэд захирал Райнер Гепперт, Монгол-Хятадын асуудал хариуцсан хэлтсийн дарга Юрген Вильке нарыг хүлээн авч уулзаж, Захиргааны хэргийн шүүхийн шүүгчдийг ХБНГУ-д сургалтад хамруулах асуудлыг үргэлжлүүлэхээр тохиролцлоо. Түүнчлэн Хууль зүйн үндэсний төвийн урилгаар Монгол Улсад хүрэлцэн ирсэн АНУ-ын Техас муж улсын Уэслианы их сургуулийн профессор Жое Спурлок II-ыг хүлээн авч уулзаж, Азийн сургалтын төвд зохион байгуулагддаг сургалттай холбоотой гэрээг шинэчлэх, уг сургалтыг үргэлжлүүлэн явуулахаар тохиролцсон байна.

### **Зургаа. Сургалт, семинарын талаар**

ГТХАН-ийн “Хуульчдын сургалт ба давтан сургалт” төсөл, АНУ-ын ШЭМШХ төсөлтэй хамтран улсын хэмжээнд зохион байгуулсан **“ИХШХШ эрх зүй болон шүүхийн шийдвэр бичих арга, техник”** сэдэвт сургалтанд шүүгч Б.Бат-Эрдэнэ, Б.Ундрах нар хичээл заав. т/с

Улсын Дээд шүүх, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Улсын Ерөнхий прокурорын газар, Нээлттэй нийгэм хүрээлэнтэй /Соросын сан/ хамтарч **19** аймгийн шүүхүүдэд Эрүүгийн хуулийн **“Албадан ажил хийлгэх ял”**-ыг хэрхэн оногдуулах, уг ялыг хэрхэн эдлүүлэх талаар холбогдох албан тушаалтнуудыг оролцуулан сургалт зохион байгууллаа.т/с

Эрүүгийн хэргийн танхим 2006 оны 5 дугаар сарын 30-нд **“Эрүүгийн байцаан шийтгэх хуулийг нэг мөр хэрэгжүүлэх зарим асуудал”** сэдэвтэй семинарыг хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, өмгөөлөгчдийн дунд зохион байгуулав. м/с

**“Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааг хэрэгжүүлэхэд хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, өмгөөлөгч, шүүгч нараас цаашид анхаарах зарим асуудал”** сэдэвт ярилцлагыг Улсын Ерөнхий Прокурорын газартай, “Ханнс-Зайделийн сан”, Хууль зүйн үндэсний төв, “Эрх чөлөө төв” зэрэг байгууллагуудтай хамтран Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн хэрэгжилтийн талаар сургалтууд зохион байгууллаа.с/з

Иргэний хэргийн танхимын шүүгч, шүүгчийн туслахууд 10 дугаар сарын 20-ны өдөр Дархан-Уул, Орхон, Сэлэнгэ аймгийн шүүхийн шүүгч, ажилтан, бусад хуульчдад **“Арбитр, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны зарим асуудал”** сэдвээр сургалт зохион байгууллаа. о/н

Улсын Дээд шүүхийн Тамгын газар, “MCS” компанийн программ хангамжийн хэлтэстэй хамтран 10 дугаар сарын 19-нд **“Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем”**-ийн талаарх сургалтыг зохион байгуулж, шүүгчийн туслах, бусад ажилтнуудыг оролцуулав. м/с

Эрүүгийн хэргийн танхим, Нийслэлийн шүүхтэй хамтран **“Хүн худалдах, худалдан авах гэмт хэргийн талаарх хууль тогтоомжийг боловсронгуй болгоход оруулах миний санал”** сэдэвт уулзалт, ярилцлагыг зохион байгуулав. с/з

Шүүхийн ерөнхий зөвлөл, Хууль зүй дотоод хэргийн яам, Хууль зүйн үндэсний төвтэй хамтран зохион байгуулсан Захиргааны хэргийн шүүхийн **шүүгчийн туслах, нарийн бичгийн дарга** нарт зориулсан сургалтад Захиргааны хэргийн танхимын тэргүүний туслах С.Мөнхжаргал, шүүгчийн туслах Б.Батболор, Г.Есөн-Эрдэнэ, М.Пүрэвсүрэн, Ц.Сайхантуяа, Ж.Халиун нар хамрагдав. м/с



Харилцаа холбоо технологийн газраас 7 дугаар сарын 5-аас 7-ны хооронд зохион байгуулсан **“Байгууллага бүр web-тэй, ажилтан бүр майл-тэй болох нь”** сэдэвт сургалтанд компьютерийн мэргэжилтэн Д.Мөнхзориг, Э.Баярбаатар нар оролцлоо. м/с

Засгийн газрын захиалгын дагуу Удирдлагын академийн төрийн захиргааны менежерийн сургалтад Дотоод ажил, зохион байгуулалт, хяналтын албаны дарга Ц.Түмэнбаярыг хамруулав. м/с

Санхүү, хангамж хариуцсан ахлах шинжээч-Ерөнхий нягтлан бодогч А.Эрдэнэцэцэг “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг хэрэгжүүлэх мэдлэг олгох үндсэн сургалт”, “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тэмдэглэл бэлтгэх аргачлал, заавар” болон тайлан нэгтгэлийн программ хангамжийг хэрхэн ашиглах талаар, “Засгийн газрын худалдан авах ажиллагааны цахим сүлжээг ашиглах, түүнд тендерийн урилга, үр дүнг нийтлэх”, “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг тайлагнах журам”-ыг танилцуулах сургалт, “Төрийн өмчийн эд хөрөнгийн эзэмшилт, хадгалалт, хамгаалалтыг сайжруулах” тухай семинар сургалтанд тус тус хамрагдсан байна. м/с

Эрхэм шүүгч, ажилтнуудаа!

Тайлангийн хугацаанд бусдаасаа илүү идэвх зүтгэл, үр бүтээлтэй ажилласан Танхимын тэргүүн Ц.Амарсайхан, шүүгч А.Доржготов, Д.Тунгалаг, С.Нямжав, Ч.Ганбат, Д.Пунцаг, П.Цэцгээ, Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах албаны дарга М.Дамирансүрэн, Санхүү, хангамж, үйлчилгээний албаны дарга С.Баасанцэрэн, Танхимын тэргүүний туслах Э.Амин-Эрдэнэ, Н.Батзориг, С.Мөнхжаргал, шүүгчийн туслах Б.Цогт, Л.Ганзориг, Г.Есөн-Эрдэнэ, Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны судалгаа хариуцсан шинжээч Ц.Нарангэрэл, жолооч Б.Пүрэв, Д.Төмөрхуяг, санхтехникийн слесарь Б.Ширэндэв, үйлчлэгч Б.Уртнасан, Л.Даваажав, Д.Загдсүрэн, Д.Оюунцэцэг, Ц.Цэцэгсүрэн нарт хамт олныхоо нэрийн өмнөөс болон хувиасаа гүн талархал илэрхийлж, цаашдын ажил хөдөлмөрт нь өндөр амжилт хүсэн ерөөе!

Эрхэм шүүгч, ажилтнууд аа!

Улирч буй 2006 онд бид нилээд их зүйл хийж амжуулсан ч шинэ 2007 онд түүнээс ч их зүйл хийх шаардлагатай байна.

Улсын Дээд шүүх 2007 онд дараах зорилтуудыг дэвшүүлж байна.

1. Шүүхийн менежментийн үзэл баримтлалд заагдсан шүүхийн эрхэм зорилго, үйл ажиллагааны зорилтын дагуу хэргийн хөдөлгөөний нэгдсэн стандартыг боловсруулах;

2. Эрүү, Иргэний болон иргэн, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн шинжлэх ухааны тайлбарыг гаргаж, олон нийтийн хүртээл болгох;

3. Анхан болон давж заалдах шатны шүүхийг мэргэжлийн удирдлагаар хангах ажлыг эрчимжүүлэх;

4. Шүүн таслах ажиллагааны чанар, үр нөлөө болон шүүгч, ажилтны сахилга, хариуцлага, ёс зүй, ажил хэргийн чадвар, мэргэжлийн түвшинг дээшлүүлэхэд онцгой анхаарах;

5. Шүүгч, ажилтны нийгмийн асуудлыг шийдвэрлэх ажлын хүрээнд тэдгээрийг орон сууц худалдан авах урт хугацааны, бага хүүтэй зээлд хамруулах;

Эдгээр зорилтыг шийдвэрлэхийн төлөө хамтран ажиллацгаая.

Та бүхний цаашдын ажилд амжилт хүсье.

АНХААРАЛ ТАВЬСАНД БАЯРЛАЛАА